

Хөгжил дэвшлийг хамтдаа бүтээе!



СТРАТЕГИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛҮҮД БОЛОН ТЭМҮҮЛЛҮҮД

ШИЛДЭГ АЖИЛ ОЛГОГЧ БАЙНА

- Эрүүл, аюулгүй орчин бүрдүүлж, хүн бүрийн оролцоо, олон талт байдлыг дэмжих соёлыг төлөвшүүлнэ.
- Үе үеийн төлөөлөл мөр зэрэгцэн урам зоригтой ажиллах боломж бүрдүүлж, чадварлаг ажилтнуудыг эгнээндээ элсүүлж, тогтвортой ажиллах урам зоригоор тэтгэнэ.
- Дэлхийн түвшинд үнэлэгдэхүйц өндөр ур чадвартай мэргэжилтэн бэлтгэнэ.

ЭХ ДЭЛХИЙГЭЭ ЭРХЭМЛЭН ХАМГААЛНА

- Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах дэлхий нийтийн үйлсийг компани даяараа онцгойлон чухалчилж, биелүүлэх арга замыг эрэлхийлнэ.
- Биологийн төрөл зүйлийн олон янз байдлыг хамгаалж, сайжруулна.
- Компанийн үйл ажиллагаанаас газар, ус, агаарын чанарт учирч болох сөрөг нөлөөллөөс сэргийлж бууруулна.
- Улс орны хэмжээнд усны аюулгүй байдлыг хангах чиглэлээр хамтарч ажиллана.
- Уурхайн хаалтын дараах нөлөөллийг туйлын багасгахад чиглэсэн бизнесийн үйл ажиллагааг явуулна.



ХӨГЖИЛ ДЭВШЛИЙН ТҮНШ БАЙНА

- Хувьцаа эзэмшигч болон оролцогч талуудтай итгэлцэлд суурилсан харилцааг хөгжүүлж төлөвшүүлнэ.
- Харилцан ашигтай зорилгын төлөө оролцогч талуудтайгаа нэгдэнэ.
- Үндэсний хэмжээнд болон орон нутгийн түвшинд эдийн засгийг төрөлжүүлэн хөгжүүлэх үйл явцыг хурдасгах зорилгоор бизнесийн түншүүдтэйгээ хамтарч ажиллана.
- Үйл ажиллагаа явуулж буй орон нутагт тогтвортой хөгжлийг дэмжих чиглэлээр түншилж ажиллана.

ТОГТВОРТОЙ ҮНЭ ЦЭН БҮТЭЭНЭ

- Урт хугацаанд үр ашгаа хүртээх, дэлхийд тэргүүлэх зэсийн үйлдвэрлэлийг цогцлооно.
- Стратегиа оновчтой төлөвлөж, хүдрийн биетийн судалгаанд хөрөнгө оруулах замаар үр ашгийг боломжит дээд түвшинд хүргэж нэмэгдүүлнэ.
- Нэгдмэл, уян хатан бодлоготой, шинийг санаачлагч байж, шинэ техник, технологи ашиглагч, тасралтгүй суралцаж хөгжигч тэргүүний компани байна.
- Ханган нийлүүлэлтийн сүлжээ, түүний дотор цахилгаан эрчим хүчний чадамж, тогтвортой байдлыг сайжруулж, дээд зэрэглэлийн бүтээгдэхүүнийг илүү олон харилцагчдад нийлүүлнэ.

Хөгжил дэвшлийг хамтдаа бүтээе!



Хамт олон

ШИЛДЭГ АЖИЛ
ОЛГОГЧ БАЙНА




Хамтын
ажиллагаа



Хөрст дэлхий



Хүртэх өгөөж



АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА, ЭРҮҮЛ МЭНД

Аюулгүй ажиллагаа нь бидний нэн тэргүүний зорилт. Аюултай гэж үзсэн ямар ч ажлыг ажилтан бүр шууд зогсоох эрхтэй.

2023 ОНЫ БАЙДЛААР

35,975,362 ХҮН/ЦАГ

2023 оны эхний дөрвөн улиралд гэмтэл, бэртлийн давтамжийн үзүүлэлт 200,000 хүн/цаг тутамд 0.20 ногдож байгаа нь Рио Тинто группийн хэмжээнд аюулгүй ажиллагааг сайн хангадаг уурхайн нэг болж байна.



ГЭМТЭЛ, БЭРТЛИЙН ДАВТАМЖИЙН ҮЗҮҮЛЭЛТ

*0.23-ААС БАГА БАЙЛГАХ

ГҮЙЦЭТГЭЛ **0.20**



БОЛОВСРОЛ СУРГАЛТ (НИЙТ ХҮН/ЦАГ)

2023 онд нийт 820,412 хүн/цагийн сургалтад ажилтнуудаа хамруулан ур чадварыг нь өсгөсөөр байна.

БОЛОВСРОЛ, ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР

ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭН ДАХЬ

2010 оноос хойш **2,048** сурагч/оюутан Залуусын хөгжлийн хөтөлбөр, Дотоодын болон гадаадын тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдлаа.

ӨМНӨГОВИЙН ХЭМЖЭЭН ДАХЬ

2016 оноос хойш **537** оюутан Говийн оюу оюутны тэтгэлэг, Малчин өрхийн оюутны тэтгэлэгт хамрагдлаа.

КАРЬЕР ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР

2013 оноос хойш **1,558** сургагчид Шинэ төгсөгчийн хөтөлбөр, Дадлагын болон Дадлагжигч хөтөлбөр, Ажил, хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрт хамрагдлаа.



ХАМТ ОЛОН

97.2%

ҮҮРЭГ 90%

Нийт ажиллах хүчний 97.2 хувийг монгол иргэн бүрдүүлж байна. Харин 33,23 хувь нь гүний уурхайн төслийн ажилтнууд юм.



ЭМЭГТЭЙ АЖИЛТАН

23.3%

2023 ОНЫ ЗОРИЛТ 25%

МАНАЙ АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

2023 оны IV улирлын тойм мэдээ



Хөгжил дэвшлийг хамтдаа бүтээе!



Хамт олон



Хамтын ажиллагаа

ХӨГЖИЛ ДЭВШЛИЙН ТҮНШ БАЙНА



Хөрст дэлхий



Хүртэх өгөөж



ОРОН НУТГИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРҮҮД



66%



ГОВИЙН ОЮУ
ХӨГЖЛИЙГ
ДЭМЖИХ САН

34%



ХАНБОГДЫН
ХӨГЖЛИЙГ
ДЭМЖИХ
ОЮУ ТОЛГОЙН
ХУРДАСГУУР САН

Тогтвортой хөгжилд чиглэсэн төслүүдэд 2023 оны дөрөвдүгээр улирлын байдлаар 28.5 тэрбум төгрөгийн санхүүжилт олгожээ.

Эрүүл мэнд, сайн сайхан байдал	4%
Боловсрол	39%
Байгаль орчин	5%
Орон нутгийн бизнесийн хөгжил	0.2%
Түүх, соёл	2%
Дэд бүтэц	49%
Спорт	0.8%

ТАТВАР, ХУРААМЖ, БУСАД ТӨЛБӨР

(2010 - 2023)

10.3
2010 ОНООС
ХОЙШ ӨССӨН
ДҮНГЭЭР

ИХ НАЯД ТӨГРӨГИЙГ

ТАТВАР ХУРААМЖ, БУСАД ТӨЛБӨРТ ТӨЛЖЭЭ.

Татвар, хураамж, үндэсний компаниудад төлсөн НӨАТ* зэрэг бусад төлбөрт 10.3 их наяд төгрөг** 2010 оноос хойш төлсөн.

* "Оюу толгой" ХХК НӨАТ-ын буцаан авалт хийдэггүй.

** Энэ дүнд олон улсын арбитра хэлэлцэгдэж буй 1 их наяд төгрөгийн татварын маргааны төлбөр багтсан болно.

ДОТООДОД ЗАРЦУУЛСАН НИЙТ МӨНГӨН ХӨРӨНГӨ



74%

Аж ахуй нэгж, бусад байгууллагад төлсөн төлбөр (НӨАТ-тай)

19%

Улс, орон нутгын төсөвт шууд төлсөн төлбөрүүд

7%

Цалин

Үндэсний компаниудтай хийсэн худалдан авалт, бусад хамтын ажиллагаа, төсөвт төлж буй татвар, хураамж, үндсэн ажилчдын цалинд 2010 оноос хойш 40.4 их наяд төгрөг зарцууллаа.

ДОТООДЫН ХУДАЛДАН АВАЛТ

(2010 - 2023)

28.2
ӨССӨН ДҮНГЭЭР

ИХ НАЯД ТӨГРӨГ

2023 оны эцэст үйл ажиллагааны худалдан авалтын баг 969 ханган нийлүүлэгчтэй хамтран ажилласны 700 нь дотоодын ханган нийлүүлэгчид байв. Эдгээр дотоодын компанид худалдан авалтынхаа 89 хувийг зарцуулав. 2010 оноос хойш дотоодын худалдан авалтад 28.2 их наяд төгрөг зарцуулсан.

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХЭМЖЭЭНД ХИЙСЭН ХУДАЛДАН АВАЛТ

(2010 - 2023)

3.9
ИХ НАЯД ТӨГРӨГ

2023 оны эцэст Өмнөговь аймагт бүртгэлтэй 104 ханган нийлүүлэгчээс 945.3 тэрбум төгрөгийн бараа, үйлчилгээ авлаа. 2010 оноос хойш Өмнөговь аймгаас нийт 3.9 их наяд төгрөгийн бараа, үйлчилгээ авчээ.

МАНАЙ АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

2023 оны IV улирлын тойм мэдээ



Хөгжил дэвшлийг хамтдаа бүтээе!



Хамт олон



Хамтын ажиллагаа



Хөрст дэлхий

ЭХ ДЭЛХИЙГЭЭ
ЭРХЭМЛЭН ХАМГААЛНА



Хүртэх өгөөж



УС АШИГЛАСНЫ ТӨЛБӨР

(2013 - 2023, IV УЛИРАЛ)

171

ТЭРБУМ ТӨГРӨГ

2023 оны дөрөвдүгээр улирлын байдлаар ус ашигласны төлбөрт 171 тэрбум төгрөг төлсөн.

85.7%

2023 оны дүрэвдүүгээр улирлын байдлаар ус дахин ашиглалтын зорилт 80 хувь байсан бол түвшинг дунджаар 85.7 хувьд хүргэв.



“100 САЯ МОД” ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ

Жилд Ханбогд суманд 250,000, Цогт-Овоо суманд 500,000 тарьц, суулгац ургуулах хүчин чадалтай хоёр мод үржүүлгийн газрыг байгуулсан.

Богд уулын Түргэний аманд түймэрт өртсөн 70 га талбайг хашаажуулж, 38 га талбайд ойжуулалтын ажил гүйцэтгэн нийт 95,000 ширхэг мод тарьсан.


Сэлэнгэ аймгийн Ялбагийн хөндий дэх, хариуцлагагүй уул уурхайн үйл ажиллагааны нөлөөгөөр хөндөгдөж, орхигдсон 400.4 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийсэн.

Нийт 58,503 мод, тарьц, суулгацыг 3,067 ажилтанд тараасан.

Ханбогд сумын угтах хаалганы ойн зурвас 17 га талбайд, 15,000 мод тарьсан.

УСНЫ ХЭРЭГЛЭЭ


(НЭГ ТОНН ХҮДЭР БОЛОВСРУУЛАХАД ЗАРЦУУЛСАН УСНЫ ХЭМЖЭЭ, ШОО МЕТР, САРААР)



Нэг тонн хүдэр боловсруулахдаа нөхөн сэлбэлтээр 0.39м³ буюу дэлхийн ижил төрлийн уурхайнуудын ашиглалтын дунджаас даруй гурав дахин бага ус ашиглаж байна.

ДАХИН БОЛОВСРУУЛАХ ХАЯГДЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

(ХУВЬ, САРААР)



2023 оны дөрөвдүгээр улирлын байдлаар нийт үүссэн хаягдлын 61 хувь нь дахивар нөөц байна.

МАНАЙ АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

2023 оны IV улирлын тойм мэдээ



Хөгжил дэвшлийг хамтдаа бүтээе!



Хамт олон



Хамтын ажиллагаа



Хөрст дэлхий




Хүртэх өгөөж

ТОГТВОРТОЙ
ҮНЭ ЦЭН БҮТЭЭНЭ



ҮЙЛДВЭРЛЭСЭН БАЯЖМАЛ ДАХЬ ЗЭСИЙН ХЭМЖЭЭ


(МЯН.ТОНН)



Бид 2023 оны дөрөвдүгээр улирлын байдлаар зорилтоо давж, нийт 168,094 тонн баяжмал дахь зэс үйлдвэрлэв.

ҮЙЛДВЭРЛЭСЭН БАЯЖМАЛ ДАХЬ АЛТНЫ ХЭМЖЭЭ


(МЯН.УНЦ)



Бид 2023 оны дөрөвдүгээр улирлын байдлаар зорилтоо давж, нийт 177,312 унц баяжмал дахь алт үйлдвэрлэв.

ГҮНИЙ УУРХАЙН ХӨНДЛӨН НЭВТРЭЛТ

(МЕТР, САРААР)



Бид 2023 онд гүний уурхайд хөндлөн малталтын гүйцэтгэлийн хувьд 15,692 метрийн ахицтай байв.

МАНАЙ АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

2023 оны IV улирлын тойм мэдээ



OTMongolia



OTMongolia



Oyu Tolgoi



OTMongolia



OTMongolia